



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/106

Хажуу шинэ ус

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дүгээр зүйлийн 17.2 дахь хэсэг, Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийн 24-5659 дугаартай шинжилгээний бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Ажирхай багийн нутаг “Элгэн”-д нутаглаж байгаа малчны суурьт галзуу өвчний гарсан тул голомтын бүсэд хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2.Хорио цээрийн дэглэм тогтоосон бүс нутагт урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч дархлаажуулалт, ариутгал халдваргүйтгэл ажлыг зохион байгуулахыг Угтаал чандмань хоршооны малын эмч (Д.Амгалан)-д үүрэг болгосугай.

3.Голомт тогтоосон нутагын хүн малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, иргэдэд урьдчилан сэргийлэх анхааруулга өгч ажиллахыг 1 дүгээр багийн Засаг дарга (Б.Мөнхдэлгэр)-д даалгасугай.

4.Өвчний нөхцөл байдлыг тогтмол мэдээлж нэгдсэн арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (А.Бямбадорж)-д үүрэг болгосугай.



ДАРГА

Т.АРИУНАА

482401106